



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас/факс: (976-11) 329084
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2013.08.13 № 113204
танай _____-ны № _____-Т


УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Ш.ТҮВДЭНДОРЖ ТАНАА

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй
хоршоодын 2013 оны хоёрдугаар улирлын санхүүгийн
тайлангийн нэгтгэлийн танилцуулга болон хураангуй
тайланг хүргүүлж байна.

Хавсралт 19 хуудас.


Хүндэтгэсэн

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

032016



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

(2013 оны хоёрдугаар улирал)

Улаанбаатар хот

ГАРЧИГ

I. ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

II. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Ерөнхий статистик үзүүлэлтүүд
- Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд
- Хасбанкны франчайзийн гэрээтэй ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

III. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- Активын чанар
- Зээлийн багцын чанар

IV. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

V. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- Орлогын үзүүлэлтүүд
- Зардлын үзүүлэлтүүд
- Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д
- Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

VI. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭВЭЛ

VII. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

VIII. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

IX. ХАВСРАЛТ

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2013 ОНЫ
ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2013.08.05

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 2 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 17 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2013 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 142 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

ХЗХ-ны тооны өөрчлөлтийг сүүлийн 8 жилийн байдлаар харуулбал:



Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Онууд	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	ХЗХ-дын тоо
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010	2	35	15	4	80	179
2011	4	21	9	-	47	162
2012	3	17	7	4	26	148
2013-1	-	4	-	-	27	144
2013-2	-	2	1	-	17	142

Нийт ХЗХ-дын 97.9 хувь буюу 139 ХЗХ 2013 оны хоёрдугаар улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан ирүүлсэн, харин 2.1 хувь буюу 3 нь тайлан мэдээг ямар нэг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй байна.

2013 оны хоёрдугаар улирлын байдлаар санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан мэдээгээ ирүүлээгүй 3 ХЗХ-ны нэгтгэлд хамруулсан үеийн буюу хамгийн сүүлд Хороонд ирүүлсэн санхүүгийн тайланг хугацааны хувьд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Тайлангийн хугацаа	ХЗХ-ны тоо	ХЗХ-дын нэрс
1	2012- I улирлаар	1	Увс аймгийн Хяргас хас
2	2013- II улирлаар	2	Өвөрхангай аймгийн Найдвартай хөгжил, Хөвсгөл аймгийн Баруун отог
Нийт		3	


ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2.1 Ерөнхий статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны II улирал	2013 оны II улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	156	142	(14)	-9.0
2	Гишүүдийн тоо	27,325	26,422	(903)	-3.3
3	Нийт актив	64,483,328.2	71,854,972.8	7,371,645	11.4
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.6%</i>	<i>0.5%</i>	(0.1)	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	49,319,969.4	56,424,662.0	7,104,693	14.4
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.8%</i>	<i>0.7%</i>	(0)	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	2,092,449.8	1,566,451.7	(525,998)	-25.1
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.7%</i>	<i>0.5%</i>	(0)	
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	45,225,269.1	49,552,850.9	4,327,582	9.6
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>1.1%</i>	<i>1.0%</i>	(0)	
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	8,955,150.6	9,695,640.8	740,490	8.3
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>3.1%</i>	*		
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	5,690,772.9	6,957,940.8	1,267,168	22.3
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	1,433,440.1	1,350,746.8	(82,693)	-5.8
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	394,654.7	519,442.5	124,788	31.6
11	Нийт орлого	8,253,917.4	8,439,235.1	185,318	2.2
12	Нийт зардал	6,100,362.1	6,580,600.9	480,239	7.9
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	2,153,555.3	1,858,634.2	(294,921)	-13.7

Тайлант улиралд ХЗХ-дод Банк болон ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн үлдэгдэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 3 ХЗХ-нд 1,084,009.2 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй Хасбанктай франчайзын гэрээтэй 15 ХЗХ-нд 266,737.6 мянган төгрөг, салбарын хэмжээнд нийт 18 ХЗХ-нд 1,350,746.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 82,693.3 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 142 ХЗХ-д байгаагийн 41.5 хувь буюу 59 ХЗХ нь Улаанбаатар хотод, 58.5 хувь буюу 83 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 оны хоёрдугаар улирлын байдлаар 142 ХЗХ-дын орон нутгийн байршлыг үзүүлбэл:



2.2 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны II улирал	2013 оны II улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	69	59	(10)	-14.5
2	Гишүүдийн тоо	12,021	11,467	(554)	-4.6
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	44.2%	41.5%	-2.6%	-5.9
3	Нийт актив	55,850,900.9	62,067,391.5	6,216,490.62	11.1
	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	86.6%	86.4%	-0.2%	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	42,606,478.2	49,023,153.9	6,416,675.70	15.1
	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	86.4%	86.9%	0.5%	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,621,484.6	1,370,586.2	(250,898.45)	-15.5
	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	77.5%	87.5%	10.0%	
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	41,195,448.3	44,910,017.6	3,714,569.33	9.0
	ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	91.1%	90.6%	-0.5%	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	6,219,641.1	6,809,325.2	589,684.10	9.5
	ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	69.5%	70.2%	0.7%	
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	4,763,659.9	5,810,444.9	1,046,785.03	22.0
	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	83.7%	83.5%	-0.2%	
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	1,030,750.1	1,084,009.2	53,259.09	5.2
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	197,677.1	63,628.9	-134,048.15	-67.8
11	Нийт орлого	6,896,888.9	6,930,134.4	33,245.54	0.5
12	Нийт зардал	5,163,524.3	5,454,794.1	291,269.81	5.6
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	1,733,364.6	1,475,340.3	-258,024.27	-14.9


Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 59 ХЗХ-дын нийт актив 62,067,391.5 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 86.4 хувийг, орлого 6,930,134.4 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлогын 82.1 хувийг, зардал 5,454,794.1 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт зардлын 82.9 хувийг тус тус эзэлж байна.

2.3 Олон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-лын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны II улирал	2013 оны II улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	87	83	(4.00)	-4.6
2	Гишүүдийн тоо	15,304	14,955	(349.00)	-2.3
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	<i>55.8%</i>	<i>58.5%</i>	<i>2.6%</i>	
3	Нийт актив	8,623,427.3	9,787,581.3	1,164,154.03	13.5
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	<i>13.4%</i>	<i>13.6%</i>	<i>0.2%</i>	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	6,713,491.1	7,401,508.1	688,017.05	10.2
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>13.6%</i>	<i>13.1%</i>	<i>-0.5%</i>	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	470,965.2	195,865.6	(275,099.65)	-58.4
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>22.5%</i>	<i>12.5%</i>	<i>-10.0%</i>	
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	4,029,820.8	4,642,833.3	613,012.51	15.2
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>8.9%</i>	<i>9.4%</i>	<i>0.5%</i>	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	2,735,509.5	2,886,315.6	150,806.12	5.5
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>30.5%</i>	<i>29.8%</i>	<i>-0.7%</i>	
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	927,113.0	1,147,495.8	220,382.83	23.8
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	<i>16.3%</i>	<i>16.5%</i>	<i>0.2%</i>	
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	402,690.0	266,737.6	(135,952.39)	-33.8
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	196,977.6	455,813.6	258,835.96	131.4
11	Нийт орлого	1,357,028.5	1,509,100.6	152,072.13	11.2
12	Нийт зардал	936,837.8	1,125,806.8	188,968.96	20.2
13	Тухайн үеийн ашиг	420,190.7	383,293.9	(36,896.83)	-8.8

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 83 ХЗХ-дын актив 9,787,581.3 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.6 хувийг, орлого 1,509,100.6 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлогын 17.9 хувийг, зардал 1,125,806.8 мянган төгрөг байгаа нь хадгаламж, зээлийн хоршоодын нийт зардлын 17.1 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын гишүүдийн тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:



2.4 Хасбанкны франчайзын гэрээтэй ажиллаж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны П улирал	2013 оны П улирал	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Хас банктай франчайзийн гэрээтэй ХЗХ-дын тоо	50	49	(1)	-2.0%
2	Гишүүдийн тоо	9,902	10,477	575	5.8%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	36.2%	39.7%	3.5%	
3	Нийт актив /мян.төг/	4,387,056.9	5,096,095.0	709,038	16.2%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	6.8%	7.1%	0.3%	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	3,371,921.7	4,004,206.2	632,284	18.8%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	6.8%	7.1%	0.3%	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	45,602.2	75,769.2	30,167	66.2%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	2.2%	4.8%	2.6%	
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	1,455,665.5	1,901,981.4	446,316	30.7%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	3.2%	3.8%	0.6%	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	1,724,152.2	1,739,499.2	15,347	0.9%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	19.3%	17.9%	-1.4%	
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	560,601.2	662,479.8	101,879	18.2%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	9.9%	9.5%	-0.4%	
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	402,690.0	266,737.6	(135,952)	-33.8%
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	124,901.0	366,134.1	241,233	193.1%
11	Нийт орлого /мян.төг/	702,178.7	798,691.3	96,513	13.7%
12	Нийт зардал /мян.төг/	470,977.0	579,259.4	108,282	23.0%
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	231,201.7	219,431.8	(11,770)	-5.1%

ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Активын чанар

ХЗХ-дын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2012/06/30		2013/06/30		/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	63,072,206.0	97.8%	70,195,432.7	97.7%	7,123,226.7	11.3%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,123,434.7	18.8%	11,694,117.4	16.3%	(429,317.3)	-3.5%
Касс дахь бэлэн мөнгө	2,457,791.8	3.8%	2,340,739.3	3.3%	(117,052.5)	-4.8%
Банкинд байршуулсан харилцах	6,798,550.5	10.5%	6,574,096.2	9.1%	(224,454.3)	-3.3%
Банкинд байршуулсан хадгаламж	2,867,092.5	4.4%	2,779,282.0	3.9%	(87,810.5)	-3.1%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	47,646,771.0	73.9%	55,527,246.9	77.3%	7,880,475.9	16.5%
Нийт зээл	49,319,969.4	76.5%	56,424,662.0	78.5%	7,104,692.7	14.4%
Хэвийн зээл	46,137,948.7	71.6%	53,495,666.5	74.4%	7,357,717.8	15.9%
Хугацаа хэтэрсэн зээл	1,089,570.9	1.7%	1,362,543.8	1.9%	272,973.0	25.1%
Чанаргүй зээл	2,092,449.8	3.2%	1,566,451.7	2.2%	(525,998.1)	-25.1%
<i>Хэвийн бус</i>	437,098.4	0.7%	612,884.3	0.9%	175,786.0	40.2%
<i>Эргэлзээтэй зээл</i>	329,561.3	0.5%	563,431.6	0.8%	233,870.3	71.0%
<i>Муу зээл</i>	1,325,790.1	2.1%	390,135.8	0.5%	(935,654.3)	-70.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	1,673,198.4	2.6%	897,415.1	1.2%	(775,783.3)	-46.4%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,619,812.0	4.1%	2,343,364.6	3.3%	(276,447.4)	-10.6%
Байгууллага, хүмүүсээс авах авлага	432,936.9	0.7%	225,931.22	0.3%	(207,005.7)	-47.8%
Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрс/сан	29,677.2	0.0%	29,028.28	0.0%	(648.9)	-2.2%

Хадгаламж, зээлийн хоршоодын 2013 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга


Санхүүгийн зохицуулах хороо

Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,216,552.3	3.4%	2,146,461.62	3.0%	(70,090.7)	-3.2%
БУСАД ХӨРӨНГӨ	203,632.5	0.3%	135,762.7	0.2%	(67,869.8)	-33.3%
Материал үнэ бүхий зүйл	118,999.5	0.2%	117,579.0	0.2%	(1,420.5)	-1.2%
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	30,144.3	0.0%	11,749.3	0.0%	(18,395.0)	-61.0%
Бусад актив	54,488.7	0.1%	6,434.3	0.0%	(48,054.3)	-88.2%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	478,555.8	0.7%	494,941.1	0.7%	16,385.3	3.4%
Өмчлөх бусад хөрөнгө	494,981.9	0.8%	498,196.3	0.7%	3,214.4	0.6%
Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан	16,426.1	0.0%	3,255.2	0.0%	(13,170.9)	-80.2%
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,411,122.2	2.2%	1,659,540.2	2.3%	248,418.0	17.6%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,363,687.5	2.1%	1,609,545.6	2.2%	245,858.1	18.0%
Үндсэн хөрөнгө	1,815,684.5	2.8%	2,061,120.5	2.9%	245,436.1	13.5%
Үндсэн хөрөнгийн элэгдэл	451,997.0	0.7%	451,575.0	0.6%	(422.0)	-0.1%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	47,434.8	0.1%	49,994.6	0.1%	2,559.9	5.4%
Биет бус хөрөнгө	32,489.3	0.1%	16,454.6	0.0%	(16,034.7)	-49.4%
Бусад	14,945.4	0.0%	33,540.0	0.0%	18,594.6	124.4%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	64,483,328.2	100.0%	71,854,972.8	100.0%	7,371,644.6	11.4%

Активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.4 хувиар буюу 7,371,644.6 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.4 хувиар буюу 7,104,692.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 525,998.1 мянган төгрөгөөр, зээлийн болзошгүй эрсдэлийн сан 775,783.3 мянган төгрөгөөр тус тус буурч зээлийн багцын чанар сайжирсан байна.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар харуулбал:



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Активын хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт актив	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	32,365,010.7	45.0%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	8	23,266,415.4	32.4%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	5	3,802,871.7	5.3%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	45	9,622,930.5	13.4%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	21	1,379,069.8	1.9%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	50	1,341,208.9	1.9%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	9	67,498.9	0.1%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	3	9,966.8	0.0%
	Нийт дүн	142	71,854,972.8	100.0%

ХЗХ-ны активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 1 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 9 ХЗХ-ны нийт актив 55,631,426.1 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 77.4 хувийг эзэлж байна.

3.2 Зээлийн багцын чанар

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/						
ҮЗҮҮЛЭЛТ	2012/06/30	хувь	2013/06/30	хувь	ӨӨРЧЛӨЛТ	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	47,646,771.0		55,527,246.9		7,880,475.9	16.5%
Нийт зээл	49,319,969.4	100.0%	56,424,662.0	100.0%	7,104,692.7	14.4%
Хэвийн зээл	46,137,948.7	93.5%	53,495,666.5	94.8%	7,357,717.8	15.9%
Хугацаа хэтэрсэн зээл	1,089,570.9	2.2%	1,362,543.8	2.4%	272,973.0	25.1%
Чанаргүй зээл	2,092,449.8	4.2%	1,566,451.7	2.8%	-525,998.1	-25.1%
<i>Хэвийн бус</i>	437,098.4	0.9%	612,884.3	1.1%	175,786.0	40.2%
<i>Эргэлзээтэй зээл</i>	329,561.3	0.7%	563,431.6	1.0%	233,870.3	71.0%
<i>Муу зээл</i>	1,325,790.1	2.7%	390,135.8	0.7%	-935,654.3	-70.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	1,673,198.4		897,415.1		-775,783.3	-46.4%

Тайлант улирлын байдлаар ХЗХ-дын нийт зээлийн багц 56,424,662.0 мянган төгрөг байгаа нь активын 78.5 хувьтай тэнцэж байна. Цэвэр зээлийн өрийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,880,475.9 мянган төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл 525,998.1 мянган төгрөгөөр буурсан эерэг үзүүлэлтүүдтэй байна.

ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/				
д/д	Зээлийн үлдэгдэл /интервал/	ХЗХ-дын тоо	Нийт зээлийн үлдэгдэл	Нийт зээлийн дүнд эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	25,358,369.9	44.9%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	7	17,614,799.8	31.2%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	6	3,880,330.4	6.9%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	35	6,679,283.9	11.8%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	23	1,635,098.7	2.9%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	45	1,106,463.1	2.0%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	15	121,432.7	0.2%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	10	28,883.6	0.1%
	Нийт дүн	142	56,424,662.0	100.0%

Зээлийн өрийн үлдэгдлийг бүлэглэхэд 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй 14 ХЗХ-ны зээлийн өрийн үлдэгдэл 46,853,500.1 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын зээлийн өрийн үлдэгдлийн 83.0 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/						
ҮЗҮҮЛЭЛТ	2012/06/30		2013/06/30		Өөрчлөлт	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь

Санхүүгийн зохицуулах хороо

1. ӨР ТӨЛБӨР	49,837,404.7	77.3%	55,201,391.3	76.8%	5,363,986.6	10.8%
ХАДГАЛАМЖ	45,225,269.1	70.1%	49,552,850.9	69.0%	4,327,581.8	9.6%
1. Хугацаагүй	2,549,179.5	4.0%	1,929,722.2	2.7%	-619,457.3	-24.3%
2. Хугацаатай	42,676,089.6	66.2%	47,623,128.7	66.3%	4,947,039.1	11.6%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	1,433,440.1	2.2%	1,350,746.8	1.9%	-82,693.3	-5.8%
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1,335,058.2	2.1%	1,350,746.8	1.9%	15,688.6	1.2%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	98,381.9	0.2%	-	0.0%	-98,381.9	(1.0)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,784,040.8	4.3%	3,778,351.0	5.3%	994,310.2	35.7%
5. Татварын төлөх өглөг	127,302.1	0.2%	85,811.6	0.1%	-41,490.5	-32.6%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,495,120.1	3.9%	3,226,397.9	4.5%	731,277.8	29.3%
7. Өглөг	120,988.4	0.2%	430,782.0	0.6%	309,793.6	256.1%
8. Бусад пассив	40,630.3	0.1%	35,359.6	0.0%	-5,270.7	-13.0%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	394,654.7	0.6%	519,442.5	0.7%	124,787.8	31.6%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	293,177.6	0.5%	420,013.6	0.6%	126,835.9	43.3%
9. Урт хугацаат төслийн санхүүжилт	101,477.1	0.2%	99,428.9	0.1%	-2,048.1	0.0%
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	14,645,923.5	22.7%	16,653,581.6	23.2%	2,007,658.1	13.7%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	8,955,150.6	13.9%	9,695,640.8	13.5%	740,490.2	8.3%
10. Хувь нийлүүлсэн хөрөнгө	8,955,150.6	13.9%	9,695,640.8	13.5%	740,490.2	8.3%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	5,690,772.9	8.8%	6,957,940.8	9.7%	1,267,167.8	22.3%
11. Нөөцийн сан	2,179,629.1	3.4%	2,222,839.7	3.1%	43,210.7	2.0%
12. Дахин үнэлгээний сан	274,963.5	0.4%	371,677.4	0.5%	96,713.9	35.2%
13. Нийгмийн хөгжлийн сан	336,166.6	0.5%	431,303.5	0.6%	95,136.9	28.3%
14. Бусад сангууд	162,774.6	0.3%	422,608.6	0.6%	259,833.9	159.6%
15. Хандив, тусламж	43,625.5	0.1%	43,609.8	0.1%	-15.7	0.0%
16. Бусад өмч	30,986.8	0.0%	27,814.6	0.0%	-3,172.2	-10.2%
17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	2,153,555.3	3.3%	1,858,634.2	2.6%	-294,921.1	-13.7%
18. Хуримтлагдсан ашиг/алдагдал	509,071.5	0.8%	1,579,453.0	2.2%	1,070,381.5	210.3%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	64,483,328.2	100.0%	71,854,972.8	100.0%	7,371,644.6	11.4%

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,363,986.6 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ 4,327,581.8 мянган төгрөгөөр, хувь хөрөнгө 740,490.2 мянган төгрөгөөр, хоршоологчдын өмч 1,267,167.8 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ нийт активын 69.0 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийг бүлэглэн харуулбал:

д/д	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	24,482,943.2	49.4%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	4	14,613,240.5	29.5%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	7	4,769,965.9	9.6%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	19	3,487,415.1	7.0%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	15	989,728.8	2.0%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	44	1,091,704.8	2.2%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	10	68,762.4	0.1%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	26	49,090.1	0.1%
9	Хадгаламжгүй	16	0.0	0.0%
Нийт хадгаламжийн дүн		142	49,552,850.9	100.0%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 43,866,149.7 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 88.5 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй 16 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 11.3 хувийг эзэлж байгаа ба эдгээр нь зөвхөн өөрийн хөрөнгөөрөө үйл ажиллагаагаа явуулж байна.


Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг графикаар харуулбал:



Тайлант улирлын байдлаар хувь хөрөнгийн хэмжээ 9,695,640.8 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.5 хувийг эзэлж байна. Үүнийг интервалаар харуулбал:

д/д	Хувь хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хувь хөрөнгийн дүн	Нийт хувь хөрөнгөнд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	2,062,087.7	21.3%
2	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	2	1,610,890.5	16.6%
3	100,000.0-500,000.0 мянган төгрөг	14	2,527,979.3	26.1%
4	50,000.0-100,000.0 мянган төгрөг	24	1,704,611.2	17.6%
5	15,000.0-50,000.0 мянган төгрөг	50	1,423,048.0	14.7%
6	10,000.0-15,000.0 мянган төгрөг	12	136,194.0	1.4%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	25	186,589.9	1.9%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	14	44,240.3	0.5%
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	142	9,695,640.8	100.0%

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлт дараах байдалтай байна.



2013 оны хоёрдугаар улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 2,007,658.1 мянган төгрөгөөр өсч 16,653,581.6 мянган төгрөгт хүрсэн. Үүнийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/				
д/д	Өөрийн хөрөнгийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгийн дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	4,785,362.6	28.7%
2	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	5	4,116,614.7	24.7%
3	100,000.0-500,000.0 мянган төгрөг	21	4,044,832.3	24.3%
4	50,000.0-100,000.0 мянган төгрөг	29	1,983,657.1	11.9%
5	10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл	57	1,528,988.9	9.2%
6	1,000.0-10,000.0 мянган төгрөг	29	194,125.9	1.2%
Нийт өөрийн хөрөнгийн дүн		142	16,653,581.6	100.0%

Өр төлбөрийн хэмжээ нь активаас хэтэрсэн буюу өрийн хөрөнгөгүй болсон ХЗХ байхгүй. ХЗХ-дын оны эцсийн байдлаар нийт хөрөнгийн 9.7 хувьтай тэнцэх 6,957,940.8 мянган төгрөгийн хоршоологчдын өмчтэй байгааг интервалаар харуулбал:

/мянган төгрөгөөр/				
д/д	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	500,000.0-2,000,000.0 мянган төгрөг	1	2,723,274.9	39.1%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	11	2,614,146.7	37.6%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	6	414,110.3	6.0%
4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	32	947,340.2	13.6%
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг	15	185,640.3	2.7%
6	1,000.0-10,000.0 мянган төгрөг	53	227,502.4	3.3%
7	1,000.0 мянган төгрөг хүртэл	8	3,812.8	0.1%
8	Хоршоологчдын өмчгүй /алдагдал ихтэй/	16	-157,886.9	-2.3%
Нийт дүн		142	6,957,940.8	100.0%

ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2012/06/30		2013/06/30		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ОРЛОГО	7,535,061.6	91.3%	8,174,194.6	96.9%	639,133.0	8.5%
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	7,247,988.8	87.8%	7,814,684.4	92.6%	566,695.6	7.8%
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	107,151.2	1.3%	74,430.4	0.9%	-32,720.8	-30.5%
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	166,640.1	2.0%	206,436.2	2.4%	39,796.1	23.9%
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	1,014.7	0.0%	17,846.1	0.2%	16,831.4	1658.8%
Бусад хүүгийн орлого	12,266.8	0.1%	60,797.6	0.7%	48,530.8	395.6%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	529,282.6	6.4%	148,750.2	1.8%	-380,532.4	-71.9%
Элсэлтийн хураамж	5,526.2	0.1%	7,735.6	0.1%	2,209.5	40.0%
Гишүүний татвар	20,742.3	0.3%	16,602.4	0.2%	-4,139.9	-20.0%
Үйлчилгээний хураамж	74,128.8	0.9%	82,259.5	1.0%	8,130.7	11.0%
Үйл ажиллагааны бусад орлого	428,885.3	5.2%	42,152.6	0.5%	-386,732.7	-90.2%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	189,573.2	2.3%	116,290.3	1.4%	-73,282.9	-38.7%
Торгуулийн орлого	2,242.6	0.0%	-	0.0%	-2,242.6	-100.0%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	9,523.7	0.1%	7,518.0	0.1%	-2,005.7	-21.1%

Хадгаламж, зээлийн хоршоодын 2013 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Санхүүгийн зохицуулах хороо

ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	1,700.0	0.0%	35,080.5	0.4%	33,380.5	-
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	18,319.1	0.2%	2,204.5	0.0%	-16,114.6	-88.0%
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	40,203.6	0.5%	11,954.7	0.1%	-28,248.9	-70.3%
Бусад орлого	39,612.1	0.5%	59,532.6	0.7%	19,920.5	50.3%
Онцгой шинжтэй орлого	77,854.5	0.9%	-	0.0%	-77,854.5	-100.0%
Ердийн бус орлого	117.6	0.0%	0.0	0.0%	-117.6	
Нийт орлогын дүн	8,253,917.4	100.0%	8,439,235.1	100.0%	185,317.7	2.2%

2013 оны хоёрдугаар улиралд ХЗХ-дын нийт орлого 8,439,235.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 185,317.7 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар өссөн. Энэ нь зээлийн хүүгийн орлого 639,133.0 мянган төгрөгөөр өссөн бол үйл ажиллаганы бусад орлого 380,532.4 мянган төгрөгөөр, үйл ажиллаганы бус орлого 73,282.9 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2012/06/30		2013/06/30		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	4,120,063.6	67.5%	4,364,637.1	66.3%	244,573.6	5.9%
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	1,896,985.2	31.1%	2,806,470.9	42.6%	909,485.7	47.9%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх)	1,993,000.8	32.7%	1,340,095.2	20.4%	-	-32.8%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жил)	132,032.6	2.2%	129,227.3	2.0%	-2,805.3	-2.1%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	95,238.5	1.6%	83,980.7	1.3%	-11,257.8	-11.8%
Бусад хүүгийн зардал	2,806.6	0.0%	4,863.0	0.1%	2,056.4	73.3%
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	181,143.2	3.0%	352,096.5	5.4%	170,953.3	94.4%
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	173,774.0	2.8%	327,260.2	5.0%	153,486.1	88.3%
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	6,797.0	0.1%	427.0	0.0%	-6,370.1	-93.7%
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	-	0.0%	24,409.4	0.4%	24,409.4	#DIV/0!
Бусад эрсдэлийн зардал	572.1	0.0%	-	0.0%	-572.1	-100.0%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,503,606.9	24.6%	1,626,017.7	24.7%	122,410.9	8.1%
Боловсон хүчний зардал	942,926.2	15.5%	1,116,141.6	17.0%	173,215.4	18.4%
Бусад зардал	560,680.6	9.2%	509,876.1	7.7%	-50,804.5	-9.1%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	295,548.4	4.8%	237,849.5	3.6%	-57,699.0	-19.5%
Торгуулийн зардал	2,057.8	0.0%	4,076.7	0.1%	2,018.9	98.1%
Ногдол ашгийн зардал	-	0.0%	-	0.0%	-	
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	371.5	0.0%	495.0	0.0%	123.5	33.3%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	28,515.9	0.5%	816.7	0.0%	-27,699.2	-97.1%
Үйл ажиллагааны бус бусад зардал	28,455.8	0.5%	21,426.3	0.3%	-7,029.5	-24.7%
Ердийн бус зардал	989.7	0.0%	1,974.1	0.0%	984.3	99.5%
Татварын зардал	235,157.8	3.9%	209,060.7	3.2%	-26,097.0	-11.1%
Нийт зардлын дүн	6,100,362.1	100.0%	6,580,600.9	100.0%	480,238.8	7.9%

Тайлант улиралд ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 6,580,600.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 480,238.8 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар өсчээ. Үүнд хадгаламжийн хүүгийн зардал 244,573.6 мянган төгрөгөөр, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 170,953.3 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 122,410.9 мянган төгрөгөөр тус тус

өссөн, харин үйл ажиллагааны бус зардал 57,699.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлтүүд нөлөөлсөн байна.

5.3 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д

Нийт 142 ХЗХ-дын 11.3 хувь буюу 16 ХЗХ тайлант улиралд 64,340.4 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/				
д/д	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
1	5,000.0 мянган төгрөгөөс дээш	4	(47,648.7)	74.1%
2	1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	7	(15,439.6)	24.0%
3	100.0-500.0 мянган төгрөг хүртэл	3	(1,086.9)	1.7%
4	100.0 мянган төгрөг хүртэл	2	(165.1)	0.3%
	Нийт дүн	16	(64,340.4)	100.0%

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 8 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ба тэдгээрийн алдагдлын хэмжээ 46,525.5 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт алдагдлын 72.3 хувийг эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 8 ХЗХ тайлант улиралд 17,814.9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ХЗХ-дын нийт алдагдлын 27.7 хувийг эзэлж байна. Үүний дотор Хасбанктай франчайзын гэрээтэй 3 ХЗХ-ны 1,823.6 мянган төгрөгийн алдагдал нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан ХЗХ-дын алдагдлын 10.2 хувийг, ХЗХ-дын нийт алдагдлын 2.8 хувийг тус тус эзэлж байна.

5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

Нийт 142 ХЗХ-доос 88.7 хувь буюу 126 ХЗХ тайлант улиралд 1,922,974.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/				
д/д	Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	2	876,060.4	45.6%
2	50,000.0-100,000.0 мянган төгрөг хүртэл	5	322,998.4	16.8%
3	10,000.0-50,000.0 мянган төгрөг хүртэл	24	517,449.2	26.9%
4	5,000.0-10,000.0 мянган төгрөг хүртэл	13	96,302.0	5.0%
5	1,000.0-5,000 мянган төгрөг хүртэл	44	95,803.4	5.0%
6	1,000.0 мянган төгрөг хүртэл	38	14,361.1	0.7%
	Нийт дүн	126	1,922,974.6	100.0%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 51 ХЗХ тайлант улиралд 1,521,865.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь ХЗХ-дын нийт ашгийн 79.1 хувийг эзэлж байна.

Харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 75 ХЗХ тайлант улиралд 401,108.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь ХЗХ-дын нийт ашгийн 20.9 хувийг, Хасбанктай франчайзын гэрээтэй 46 ХЗХ нийт 221,255.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан ХЗХ-дын нийт ашгийн 55.2 хувийг тус тус эзэлж байна.

**ЗУРГАА. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ
АКТИВААР БҮЛЭГЛЭВЭЛ:**

Хорооноос ХЗХ-дод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй ХЗХ-дыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор активын хэмжээгээр нь 4 ангилж бүлэглэвэл:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах ХЗХ-н тоо	ХЗХ-нд эзлэх хувь	Нийт активт эзлэх хувь	Үүнээс	
					УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ын тоо
Бүлэг-1	50.0 сая төгрөг хүртэл	61	43.0%	1.9%	20	41
Бүлэг-2	50-500.0 сая төгрөг	67	47.2%	15.3%	28	39
Бүлэг-3	500.0-1.0 тэрбум төгрөг	5	3.5%	5.3%	2	3
Бүлэг-4	1.0 тэрбумаас дээш	9	6.3%	77.5%	9	-
Нийт дүн		142	100.0%	100.0%	59	83

**ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР**

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдаж, 2012 оны 62, 2013 оны 79 дүгээр тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт орсон “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
A	АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН		
1	АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	893,199.9	897,415.1 Илүү байгуулсан
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	5.00%-иас бага	2.7%
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	30.00%--иас бага	Тооцох боломжгүй
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ		
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ	60%-80% хүртэл	78.5%
5	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5.00% -иас бага	0.7%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10.00%-иас бага	2.2%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	80.00%-иас бага	69.0%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20.00%-иас бага	2.5%
9	ГИШҮҮДИЙН НИЙТ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5.00%-иас их	13.5%
10	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10.00%-иас бага	Тооцох боломжгүй
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ /мянган төгрөг/	1,043,691.1	2,222,839.7
В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ		
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН	15.00%-иас бага	7.4%
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР		
13	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	5.00%-иас их	11.9%
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)		
14	АКТИВЫН ӨГӨӨЖ		3.1%

Хадгаламж, зээлийн хоршоодын 2013 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр активын эрсдэлийн санг 4,215.2 мянган төгрөгөөр илүү байгуулснаас бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

Тайлант улирлын байдлаар Хорооноос журмаар тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг 19 ХЗХ бүрэн хангаж ажилласан, 114 ХЗХ 1-4 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 8 ХЗХ 5-7 үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, 1 ХЗХ 8-аас дээш шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй үзүүлэлттэй байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2013 оны хоёрдугаар улирлын байдлаар 142 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байгаа нь 2012 оны мөн үетэй харьцуулахад тооны хувьд 14-өөр буурсан хэдий ч санхүүгийн болон үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн хувьд тодорхой хэмжээний өсөлтүүд гарч чанарын ахицтай байна. Тухайлбал:

1. Нийт актив

Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7,371,644.6 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өсөж, банкны салбарын 0,5 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд дундаж активын хэмжээ 1,051,989.7 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж ХЗХ-ны дундаж активын хэмжээ 117,922.7 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-ны хувьд 242,556.3 мянган төгрөгөөр, орон нутгийн ХЗХ-ны хувьд 18,802.8 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2. Нийт зээлийн өрийн үлдэгдэл

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 7,104,692.7 мянган төгрөгөөр буюу 14.4 хувиар өсөж, банкны салбарын 0.7 хувийг эзэлж байна. Чанаргүй зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 525,998.1 мянган төгрөг буюу 25.1 хувиар буурсан байна. Тайлант улиралд муу зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 935,654.3 мянган төгрөгөөр, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 775,783.3 мянган төгрөгөөр тус тус буурсан сайн үзүүлэлттэй байна.

3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

ХЗХ-дын хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4,327,581.8 мянган төгрөгөөр буюу 9.6 хувиар өсөж, банкны салбарын 1.0 хувийг эзэлж байна. Нийт мөнгөн хадгаламжийн 96.1 хувь нь хугацаатай, 3.9 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

4. Хувь хөрөнгийн хэмжээ

Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 740,490.2 мянган төгрөгөөр өссөн байна.

5. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеийн байдлаас 1,267,167.8 мянган төгрөгөөр өссөн. Хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн нь бусдын өмнө ХЗХ-дын хүлээх үүрэг хариуцлага өндөржиж, өөрийн хөрөнгийн чадавхи дээшилсэн эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна.

6. Нийт орлого, ашиг

ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 185,317.7 мянган төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 480,238.8 мянган төгрөгөөр тус тус өсч 2013 оны хоёрдугаар улирлын байдлаар тайлант үеийн ашиг 1,858,634.2 мянган төгрөг байна. Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 294,921.1 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ХЗХ-доос 2012 оны зохицуулалтын үйлчилгээний хөлс 14,020.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 2013 оны эхний хагас жилийн байдлаар 14,000.3 мянган төгрөг буюу 99.6 хувийг төсөвт төвлөрүүлсэн ба төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээний нэмэлт зөвшөөрөл олгосон 2 хоршооноос нэг удаа төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс болох 200.0 мянган төгрөгийг төвлөрүүлж нийт 14,200.3 мянган төгрөг төлөгдсөн байна.

Аудитын тухай хуулиар ХЗХ-д нь санхүүгийн жилийн эцсийн тайлангаа баталгаажуулах үүрэгтэй. 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 144 хоршоо аудитын байгууллагаар баталгаажуулан ирүүлэхээс 94.4 хувь буюу 136 ХЗХ аудитын дүгнэлт, аудитлагдсан тайлангаа эхний хагас жилийн байдлаар ирүүлээд байна.

Мөн “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хуульд заасан хугацаанд хийсэн Бүх гишүүдийн ээлжит хурлын тэмдэглэл, шийдвэрийг 144 хоршоо ирүүлэх ёстойгоос эхний хагас жилийн байдлаар 134 ХЗХ-ноос холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 93.1 хувьтай байна.

Тус хэлтсийн хянан шалгагчид 2013 оны эхний хагас жилд Хорооны даргын баталсан 5 удаагийн тушаалаар нэр бүхий 24 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж 9 ХЗХ-нд УБАШ-аар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулсан, 7 ХЗХ-ны удирдлагуудад зөрчлийн тэмдэглэл үйлдэн захиргааны арга хэмжээ авч 5,615.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж 5,193.8 мянган төгрөгийн торгуулийн мөнгийг төсөвт төвлөрүүлсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 92.5 хувьтай байна.

Цаашид “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах, орон нутгийн хоршоодод газар дээрх үзлэг, шалгалтыг хийж бодит нөхцөл байдалд дүгнэлт өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ХЭЛТЭС

2013 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН ТЭНЦЭЛ

Гинүүдийн тоо:

26,422

Монголбанкны ханш: USD 1.00 = MNT

#N/A

ХӨРӨНГӨ	Нийт (төгрөгөөр)
I. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	70,195,432,655.45
I. Мөнгөн хөрөнгө	11,694,117,434.92
Касс дахь бэлэн мөнгө	2,340,739,274.12
Банкинд байршуулсан харилцах	6,574,096,192.64
Банкинд байршуулсан хадгаламж	2,779,281,968.16
Бусад байгууллагад байршуулсан харилцах	0.00
Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	0.00
II. Зээл (Цэврээр)	55,527,246,921.43
Нийт зээл	56,424,662,045.91
Хэвийн зээл	53,495,666,490.21
Хугацаа хэтэрсэн зээл	1,362,543,847.18
Чанаргүй зээл	1,566,451,708.52
Хэвийн бус зээл	612,884,344.25
Эргэлзээтэй зээл	563,431,559.42
Муу зээл	390,135,804.85
(Зээлийн эрдэлийн сан)	897,415,124.48
III. Авлага (Цэврээр)	2,343,364,561.97
Байгууллага, хүмүүсээ авах авлага	225,931,222.19
(Байгууллага, хүмүүсээ авах авлагын эрдэлийн сан)	29,028,280.63
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,146,461,620.41
IV. Бусад хөрөнгө	135,762,667.13
Материал үнэ бүхий зүйл	117,579,010.90
Урьдчилж төлсөн зардал	11,749,310.23
Бусад актив	6,434,346.00
V. Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө (цэврээр)	494,941,070.00
Өмчлөх бусад хөрөнгө	498,196,308.00
(Өмчлөх бусад хөрөнгийн эрдэлийн сан)	3,255,238.00
VI. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,659,540,191.35
Үндсэн хөрөнгө (Цэврээр)	1,609,545,550.78
Үндсэн хөрөнгө	2,061,120,542.35
(Үндсэн хөрөнгийн элдгэл)	451,574,991.56
VII. Бусад эргэлтийн бус хөрөнгө	49,994,640.57
Бнэт бус хөрөнгө	16,454,640.57
Бусад	33,540,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	71,854,972,846.80
ОР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	
I. ОР ТӨЛБӨР	55,201,391,270.32
I. Хадгаламж	49,552,850,943.02
Хугацаагүй	1,929,722,200.42
Хугацаатай	47,623,128,742.60
II. Богино хугацаат зээл	1,350,746,795.22
Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1,350,746,795.22
Богино хугацаат төслийн санхүүжилт	0.00
III. Бусад богино хугацаат өр төлбөр	3,778,351,027.31
Татварын төлөх өглөг	85,811,564.73
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3,226,397,909.34
Өдлөг	430,781,972.48
бусад пассив	35,359,580.76
IV. Урт хугацаат өр төлбөр	519,442,504.77
Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	420,013,555.42
Урт хугацаат төслийн санхүүжилт	99,428,949.35
2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	16,653,581,576.48
V. Хувь нийлүүлсэн хөрөнгө	9,695,640,816.54
Хувь нийлүүлсэн хөрөнгө	9,695,640,816.54
VI. Хөршөөлөгчдын өмч	6,957,940,759.94
Ноодийн сан	2,222,839,739.58
Дахин үнэлгээний сан	371,677,417.21
Нийгмийн хөгжлийн сан	431,303,458.24
Бусад сангууд	422,608,575.01
Хандив, тусламж	43,609,787.00
Бусад өмч	27,814,572.00
Тайлангийн үеийн ашиг/алдагдал	1,858,634,199.40
Хуримтлагдсан ашиг/алдагдал	1,579,453,011.51
ОР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,854,972,846.80

0.00

2013 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ОРЛОГО ЗАРЛАГЫН ТАЙЛАН

30/06/2013

	Дүн	Хувь
I ХҮҮГИЙН ОРЛОГО	8,174,194,559.35	96.86%
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	7,814,684,361.02	92.60%
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	74,430,368.63	0.88%
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	206,436,205.08	2.45%
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	17,846,054.63	0.21%
Бусад хүүгийн орлого	60,797,569.99	0.72%
II ХҮҮГИЙН ЗАРДАЛ	4,364,637,142.55	66.33%
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	2,806,470,901.51	42.65%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	1,340,095,217.05	20.36%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	129,227,265.13	1.96%
Банк санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	83,980,711.86	1.28%
Бусад хүүгийн зардал	4,863,047.00	0.07%
Хүүгийн цэвэр орлого	3,809,557,416.80	45.14%
III БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	352,096,504.45	5.35%
Зээлийн болзошгүй эрдлийн зардал	327,260,153.50	4.97%
Авлагын болзошгүй эрдлийн зардал	426,972.00	0.01%
Омчлох бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	24,409,378.95	0.37%
Болзошгүй эрдлийн сангуудын дараах цэвэр орлого	3,457,460,912.35	40.97%
IV ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	148,750,172.44	1.76%
Элсэлтийн хураамж	7,735,600.00	0.09%
Гишүүний татвар	16,602,397.00	0.20%
Үйлчилгээний хураамж	82,259,544.71	0.97%
Үйл ажиллагааны бусад орлого	42,152,630.73	0.50%
V ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,626,017,747.42	24.71%
Боловсон хүчний зардал	1,116,141,647.92	16.96%
Ажиллагсдын цалингийн зардал	883,979,319.12	13.43%
Пийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зардал	102,052,876.86	1.55%
Ажиллагсдын сургалтын зардал	18,466,810.00	0.28%
Түр гэрээгээр ажиллагсдын зардал	16,380,163.00	0.25%
Ажиллагсад олгосон нохон олговрын зардал	6,236,348.00	0.09%
Ажиллагсад олгосон нэмэгдэл, хөнгөлөлтийн зардал	10,595,058.73	0.16%
Урамшуулалын зардал	61,227,129.00	0.93%
Боловсон хүчний бусад зардал	17,203,943.21	0.26%
Бусад төрлийн зардал	509,876,099.51	7.75%
Зээл болон бусад авлагыг барагдуулахтай холбоотой зардал	14,707,121.20	0.22%
Санхүүгийн хураамжийн зардал	18,809,090.11	0.29%
Гишүүний татвар	20,121,916.00	0.31%
Даатгалын зардал	360,500.00	0.01%
Аудитын зардал	22,796,417.00	0.35%
Зар сурталчилгааны зардал	1,407,590.00	0.02%
Эгдэл хорогдлын зардал	59,212,882.45	0.90%
Түрээсийн зардал	122,748,783.82	1.87%
Ашиглалтын зардал (цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус)	25,141,281.44	0.38%
Үндсэн хөрөнгийн жижиг засвар, борлуулалтын зардал	7,395,942.00	0.11%
ОБҮХХ-ийн урсгал болон борлуулалтын үйл ажиллагааны зардал	31,075.00	0.00%
Бичиг хэргийн зардал	28,132,108.49	0.43%
Харуул, аюулгүй байдлын зардал	12,668,650.00	0.19%
Харилцаа холбооны зардал	39,378,860.26	0.60%
Зочин, төлөөлөгчийн зардал	3,617,840.00	0.05%
Авто хэрэгсэл, шагахуун болон тээврийн зардал	48,793,391.29	0.74%
Ариун цэвэр галын аюулгүй байдал болон бус зардал	2,181,454.00	0.03%
Газар эдлэлбэр, үл хөдлөх хөрөнгийн татвар	2,920,355.00	0.04%
Хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээний зардал	460,000.00	0.01%
Үйл ажиллагааны бусад зардал	78,990,841.45	1.20%
Үйл ажиллагааны цэвэр орлого	1,980,193,337.36	23.46%
VI ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	116,290,334.62	1.38%
Торгуулийн орлого	0.00	0.00%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	7,518,017.00	0.09%
ОБҮХХ борлуулснаар олсон орлого	35,080,517.00	0.42%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	2,204,468.04	0.03%
Тэнцийн галуурх тооцооноос орсон орлого	11,954,721.29	0.14%
Бусад орлого	59,532,611.29	0.71%
Онцгой шинжтэй орлого	0.00	0.00%
VII ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	26,814,687.88	0.41%
Торгуулийн зардал	4,076,700.00	0.06%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын зардал	495,000.00	0.01%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	816,705.18	0.01%
Үйл ажиллагааны бус бусад зардал	21,426,282.70	0.33%
Ердийн үйл ажиллагааны цэвэр орлого	2,069,668,984.11	24.52%
VIII ЕРДИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР ОРЛОГО	-1,974,052.16	-0.03%
Ердийн бус орлого	0.03	0.00%
Ердийн бус зардал	1,974,052.19	0.03%
IX ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР АШИГ	2,067,694,931.95	
Татварын зардал	209,060,732.55	3.18%
X ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	1,858,634,199.40	
НИЙТ ОРЛОГО	8,439,235,066.44	100.00%
НИЙТ ЗАРДАЛ	6,580,600,867.04	100.00%
НИЙТ АШИГ	1,858,634,199.40	100.00%